



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/07

Хэрлэн сум

Агаарын бохирдлын эх үүсвэрийн  
нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулахад  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах, айл өрх, аж ахуйн нэгжүүд болон хөдөлгөөнт авто тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг цуглуулах, сумдад хяналтын тооллого хийж дүн мэдээг мэдээллийн санд нэгтгэн шинэчлэх ажилд зориулж Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ